

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/26-18-ШТА-ГА

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463
Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан Утас: 70273465
Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn
Аудитор Ч.Загдсүрэн Утас: 70272582
Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn
Аудитор Б.Одбилэг

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ❖ Багийн түвшинд иргэдийн санал авах нэгтгэх, эрэмбэлсэн жагсаалт гаргах ажил журамд заасны дагуу хэрэгжиж байгаа боловч ажлын хэсгээс гаргасан жагсаалтад тусгагдсан төсөл арга хэмжээ хасагдаж, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ сумын ИТХ-аар батлагдаж байна.
- ❖ Зуунмод суманд малын тоо толгойн албан татвараар орлого ордог боловч энэ төрлийн татварын орлогыг ОНХС-ийн эх үүсвэрээр огт төлөвлөхгүй байна.
- ❖ Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна гэсэн ажил хийгдэхгүй байна.
- ❖ Аймгийн ИТХ-аар баталсан хандив тусламжийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй тул аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 1,200.0 сая төгрөг ОНХС-ийн эх үүсвэр бүрдүүлсэн нь холбогдох хууль, журмыг зөрчсөн байна.
- ❖ Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн 100 жилийн ойн арга хэмжээг төсөл арга хэмжээ тус бүрээр нь бус нийт дүнгээр нь баталсан нь холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн байна.
- ❖ Зарим хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг аймгийн ИТХ-аас баталсан төсөвт өртгөөс нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын ажлуудыг жижиглэн хувааж шууд гэрээ байгуулсан нь холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн байна.
- ❖ Аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудын төсөвт өртөг нэмэгдсэн, худалдан авах ажиллагаа явуулалгүй гэрээ шууд байгуулж байгаа нь зураг, төсөвгүй ажлууд батлагдсанаас шалтгаалсан байна.
- ❖ Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл гараагүй байхад 50-100 хувийн урьдчилгаа санхүүжилт олгосон зөрчил нийтлэг гарч байна.
- ❖ Сум, орон нутагт гэрээ шууд байгуулж хэрэгжсэн олон жижиг ажлууд нь ОНХС-ийн хөрөнгө үр өгөөж, ач холбогдол багатай зарцуулагдаж байна гэж дүгнэхээр байна.
- ❖ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон журмын хэрэгжилтэд 27 сумаас 4 сумын ИТХ хяналт шалгалт хийсэн байна.
- ❖ Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- ❖ ОНХС-ийн сангийн удирдлага мэдээллийн системд нийт батлагдсан төсөл арга хэмжээний 58.9 хувийг бүрэн мэдээлсэн, 0.07 хувийг дутуу, 41.03 хувийг огт мэдээлээгүй байна.
- ❖ Аудитаар илэрсэн нийт зөрчилд 4 зөвлөмж, 330.8 сая төгрөгийн 5 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, 80.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 10,712.0 сая төгрөгийн 17 албан шаардлага бичигдлээ.

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.	5
1.1. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, орлого 98.7 хувьтай биелсэн байна.	5
1.2. Сум, багийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, оролцоотой төлөвлөж байна.	6
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж, шууд гэрээгээр олон жижиг ажил гүйцэтгүүлсэн нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.....	9
2.1. Аймаг, сумын ОНХС-аас төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаа явуулахаас зайлсхийж, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах, гэрээт ажлын гүйцэтгэл гараагүй байхад 50-100 хувийн санхүүжилтийг олгожээ.	9
2.2. Сум, орон нутагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чанартай бус олон жижиг ажлууд нь төлөвлөж, хэрэгжүүлж байгаа ОНХС-ийн хөрөнгө үр өгөөж, ач холбогдлыг бууруулж байна.	15
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.....	16
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг удирдлага мэдээллийн системд бүрэн тайлагнаагүй байна.	16
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.	16
3.2. ОНХС-ийн сангийн удирдлага мэдээллийн системд 5,103.8 сая төгрөгийн 159 төсөл арга хэмжээ буюу 41.03 хувийг огт мэдээлээгүй байна.	18
ДҮГНЭЛТ:	19
ЗӨВЛӨМЖ:	20
Холбогдох байгууллагын санал:	21

Хүснэгтийн товъёг

Хүснэгт №1	Төв аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөлт гүйцэтгэл
Хүснэгт №2	Төв аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөлт
Хүснэгт №3	Төв аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа
Хүснэгт №4	Аймгийн ОНХС-ийн худалдаа авах ажиллагаа
Хүснэгт №5	Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл
Хүснэгт №6	Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төвийн ерөнхийлөн захирагч
ТЗУХ	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс
ТӨХ	Тендерийн өгөгдлийн хүснэгт
ТШЗ	Тендер шалгаруулалтын зөвлөмж
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УМС	Удирдлага мэдээллийн систем
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХҮТ	Эрчим хүчний үндэсний төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дах зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөт байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сум, багийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ болон ГХБХБГ, БЗОСК ОНӨААТҮГ, ОНӨГ, зэрэг байгууллага, аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.

Байхгүй.

Аудитын хязгаарлалт

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, MNS 68175:2020, MNS 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горим хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, боловсруулан зөвлөмж бэлтгэв.

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав.

- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоол.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн Б.Одбилэг нар гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2024 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 01-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Архангай аймгийн Төрийн аудитын газарт хүргүүллээ.

**Хүндрэл
бэрхшээл**

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ОНХС-ийн хөрөнгө оруулалттай холбоотой баримт 2024 оны 6 дугаар сарын 23-нд, СТСХ-ээс санхүүгийн сүүлийн баримтууд 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн нь аудит хийхэд хүндрэл бэрхшээлтэй байлаа.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, орлого 98.7 хувьтай биелсэн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хоёрдугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлж аймгийн ОНХС-нд шилжүүлсэн байна.

Хүснэгт №1: Төв аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөлт гүйцэтгэл

Орлогын төрөл	Газрын тосны нөөц ашигласны төлбөр 30%	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 10%	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хураамж 100%	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамж 50%	ОУ-н байгууллага ас сумдын ОНХС-д олгох урамшуулал	сая.төг Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
Төлөвлөгөө	541.7	17,776.5	80.1	1,112.9	1,160.1	20,671.3
Гүйцэтгэл	384.7	17,776.5	76.5	1,000.2	1,160.1	20,398.0
Зөрүү	157.0	-	3.6	112.7	-	273.3
Гүйцэтгэлийн хувь	71.0	100.0	95.5	89.9	100.0	98.7

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

Төв аймгийн ОНХС-нд ОНХС-аас 20,671.3 сая төгрөг төвлөрүүлэхээр тооцсон, гүйцэтгэлээр 20,398.0 сая төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувь, Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хураамж, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамжийн 50 хувь гэсэн орлогууд 71.0-95.5 хувийн биелэлттэй гарснаас шалтгаалж орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 98.7 хувь болсон байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу аймагт ОНХС-с олгосон хөрөнгийг аймаг, сумдад хуваарилсан байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн 2023 оны төсөв батлахад ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 16,368.6 сая төгрөг, үүнээс аймгийн ОНХС-нд 7,604.2 сая, сумдын ОНХС-нд 8,764.4 сая төгрөг байхаар баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийгдэж ОНХС-ийн орлогын шилжүүлэг 20,671.3 сая төгрөг, үүнээс аймгийн ОНХС-нд 9,755.6 сая, сумдын ОНХС-нд 10,915.7 сая төгрөг баталсан.

Сумдын ОНХС-нд олгох орлогын шилжүүлгийг Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 2.2, 2.4, 2.5, 2.6-д заасны дагуу тооцон хуваарилсан байна. Ингэхдээ алслалтын индекс, хүн амын тоонд жинлэсэн алслалтын индекс, итгэлцүүрийн хуваарилалт, урамшуулал, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр зэрэг үзүүлэлтээр тооцжээ./Хавсралт 1/

Сангийн яамнаас ирүүлсэн тооцооллыг үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоолоор аймаг, сумдын ОНХС-ийн орлогын шилжүүлгийг баталжээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг зааж өгсөн. Аймгийн хувьд улсын төсөв буюу ОНХС-ийн санхүүжилтээс гадна ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл, хандив тусламжийн орлого, сумдын хувьд хандив тусламж, малын тоо толгойн албан татвар, бусад гэсэн орлогуудыг төлөвлөсөн байна. Тайлант 2023 онд аймгийн болон 7 сумдын тэгш ой болсонтой холбоотойгоор ой тэмдэглэхээр хандив тусламжийн орлогыг ОНХС-аар төлөвлөжээ.

Хүснэгт №2: Төв аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөлт

Орлогын төрөл	Өмнөх оны үлдэгдэл	ТТХ-ийн 60.2.1, 60.2.6, 60.2.7 ОНХС болон улсын төсөв	ТТХ-ийн 60.2.8 Малын тоо толгойн албан татвар	ТТХ-ийн 60.2.5 Хандив тусламж	Бусад орлого	/сая.төг/ Аймаг, сумдын ИТХ-р батлагдсан орлого
Аймгийн ОНХС	307.3	9,755.6	-	3,500.0	-	13,562.9
Сумдын ОНХС	3,409.8	10,915.7	1,706.4	3,562.9	41.7	19,636.5
Нийт	3,717.1	20,671.3	1,706.4	7,062.9	41.7	33,199.4

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4-д заасан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээр орлого огт төлөвлөөгүй бол 60.2.5-д заасан хандив тусламжийн орлогоор 7,062.9 сая төгрөг төлөвлөсөн нь нийт орлогын 21.3 хувь болсон байна. Мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан малын тоо толгойн албан татварын орлогоор сумууд 1,706.4 сая төгрөг төлөвлөсөн нь нийт төлөвлөгдсөн орлогын 8.7 хувийг эзэлж байна.

Сумдаас Зуунмод сум малын тоо толгойн албан татварыг огт төлөвлөөгүй, сумын татварын орлогын дансанд 2022 оны 5.2 сая төгрөг, 2023 оны 16.4 сая төгрөг, нийт 21.6 сая төгрөгийн орлого орсныг ОНХС-нд төвлөрүүлээгүй байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.7-д "сум, дүүргийн ИТХ малын тоо толгойн албан татварын тухайн жилийн орлогыг тооцон батална" гэснийг зөрчсөн байна.

1.2. Сум, багийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, оролцоотой төлөвлөж байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлд багийн түвшинд, 6 дугаар зүйлд сумын түвшинд ОНХС-н төлөвлөхөд олон нийтийн оролцоог хангах талаарх зохицуулалт тусгагдсан.

Багийн түвшинд журамд заасан хугацаанд ИНХ хуралдуулж, иргэдийн гаргасан саналыг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлснийг тодорхой аргачлалаар боловсруулж, эрэмбэлсэн жагсаалт гарган сумын Засаг даргад хүргүүлж ажилласан байна. Багийн ИНХ-ыг хуульд заасан ирцтэйгээр хийж иргэдээс саналын хуудас болон цахим гэсэн аргаар санал авч нэгтгэсэн байна. Аудитын явцад хийсэн судалгаагаар сумдын

хэмжээнд нийт 26921 иргэн ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал өгснөөс 83 нь цахимаар, 26838 нь саналын хуудсаар санал өгчээ.

Сумын Засаг дарга ажлын хэсгийн гаргасан эрэмбэлсэн жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д оруулж байна. Багийн түвшинд иргэдийн санал авах нэгтгэх, эрэмбэлсэн жагсаалт гаргах ажил журамд заасны дагуу хэрэгжиж байгаа боловч ажлын хэсгээс гаргасан жагсаалтад тусгагдсан төсөл арга хэмжээ хасагдаж, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ ИТХ-аар батлагдах тохиолдол байна. Үүнд:

- Баяндэлгэр сумын багийн ИНХ-аас 4 ажилд санал өгснөөс 3 нь батлагдаж, иргэдээс санал аваагүй шинээр наадмын талбай байгуулах, ЗДТГ-ын дэд бүтэц, усан хангамж гэсэн ажлууд ИТХ-аар батлагдсан.
- Дэлгэрхаан сумын ажлын хэсгээс 5 ажил эрэмбэлснээс ИТХ-аар 2 нь батлагдаж, 3 нь батлагдаагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй 10 ажил батлагдсан.
- Лүн сум эрэмбэлсэн жагсаалтад ороогүй хог тээврийн машин баталсан.
- Мөнгөнморьт сум ажлын хэсгийн эрэмбэлсэн жагсаалтаар иргэдийн саналыг үндэслэн 8 ажил эрэмбэлсэн боловч 4 ажлыг цуцалж урсгал зардал 2, төрийн албан хаагчийн орон сууц гэсэн 1 ажлыг нэмж нийт 7 төсөл арга хэмжээ баталсан.
- Сүмбэр сум хүүхдийн тоглоомын талбай, хүндэтгэлийн гэр, ахуй үйлчилгээний тохижилт зэрэг 3 ажлыг иргэдээс санал аваагүй байхад ажлын хэсэг эрэмбэлсэн жагсаалтад оруулсан.
- Баянцагаан, Жаргалант, Эрдэнэ зэрэг сумдын ИТХ-аар иргэдийн санал аваагүй урсгал зардлуудыг баталжээ.

Мөн Баян сумын Засаг дарга журамд заасны дагуу ажлын хэсэг байгуулаагүй, багийн ИНХ-с гарсан саналыг эрэмбэлж жагсаалт гаргах ажил хийгдээгүй байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлд заасныг зөрчсөн байна.

Аймгийн тухайд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлд зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ны А/610 дугаар захирамжаар ХБТХОХ-ийн даргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, тус ажлын хэсэг сумдаас ОНХС-аар хэрэгжүүлэхээр гаргасан төсөл арга хэмжээнээс сум хэрэгжүүлэх боломжгүй өртөг өндөртэй саналуудыг эрэмбэлж арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргаж ажилласан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 7.5-д “урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Сумдын хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлд заасны дагуу нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөхдөө хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон бусад шалгууртай нийцүүлсэн байна. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөтэй төсөл арга хэмжээ болгоноор тулгахад нийцсэн байна.

Аймгийн төсвийг 2022 оны 12 дугаар сарын 05-нд батлахад ОНХС-аас нийт 16,368.6 сая төгрөг хуваарилагдсанаас 7,604.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-нд

хуваарилж, аймгийн 100 жилийн ойн арга хэмжээнд 3,500.0 сая төгрөг хандиваар орохоор тооцож 11,104.3 сая төгрөгөөр 27 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан. Улсын төсөвт тодотгол хийгдэж ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 20,6071.3 сая төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотойгоор орон нутгийн төсөвт тодотгол хийгдэж аймгийн ОНХС-нд 9,755.6 сая төгрөг хуваарилагдаж, 100 жилийн ойн арга хэмжээний хандивын орлогыг 3,500.0 сая төгрөгөөр тооцож 13,255.6 сая төгрөгөөр 66 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагджээ. Аймгийн төсвийн тодотголыг 2023 оны 8 дугаар сарын 04-нд буюу 100 жилийн ойн арга хэмжээ болсны дараа буюу ихэнх ажил хийгдэж, хэрэгжсэний дараа гүйцэтгэлээр нь тодотгон баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн Монгол өв соёлын цогцолбор төсөл хэрэгжүүлэх зардал 1,000.0 сая төгрөг, гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Баянхангай, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянжаргалан сумд/ 400.0 сая төгрөг, сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Баяндэлгэр, Баян Өнжүүл, Баянцагаан, Баянцогт, Заамар, Лүн, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ сумд/ 540.0 сая төгрөг, орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Баян, Баяндэлгэр, Эрдэнэсант, Баян Өнжүүл, Сүмбэр, Лүн сумд/ 600.0 сая төгрөг зэрэг ажлууд нь зураг төсөлгүй байхад жагсаалтад батлагдсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасныг зөрчсөн байна.

Аймгийн 100 жилийн ой зохион байгуулахад 3,500.0 сая төгрөгийн хандив орно гэж тооцсон хэдий ч гүйцэтгэлээр 1,995.4 сая төгрөг орсон байна. Хандив тусламжийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй тул аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс ОНХС-руу 1,200.0 сая төгрөг санхүүжүүлж, ойн арга хэмжээнд зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасныг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд зааснаар бус орон нутгийн төсвөөр бүрдүүлж, зарцуулжээ. Мөн аймгийн 100 жилийн ойн арга хэмжээг төсөл арга хэмжээ тус бүрээр нь бус нийт дүнгээр нь баталсан нь Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, 33 дугаар зүйлийн 33.2.6-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/” батална гэснийг зөрчсөн байна.

Сумдын хувьд хууль, журамд заагдаагүй зарим чиг үүргийг ОНХС-аар хэрэгжүүлэхээр баталсан тохиолдол байна. Тухайлбал:

- Батсүмбэр сум он дамжин хэрэгжих арга хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээ тусгаан баталж буцалтгүй тусламж олгосон,
- Баяндэлгэр сум ЗДТГ-ын дэд бүтэц, усан хангамж гэсэн ЗД-ын чиг үүрэгт хамаарах ажил баталсан байна.

- Баянцагаан сумын ИТХ-аар ЗДТГ-ын гадна фасад, шал, хаалга засварлах ажилд 110.3 сая төгрөгийг баталсан байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАУХАТ хуулийг зөрчиж, шууд гэрээгээр олон жижиг ажил гүйцэтгүүлсэн нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

2.1. Аймаг, сумын ОНХС-аас төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаа явуулахаас зайлсхийж, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах, гэрээт ажлын гүйцэтгэл гараагүй байхад 50-100 хувийн санхүүжилтийг олгожээ.

Аймаг, 27 сумын ИТХ-аар 2023 онд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх 32,424.5 сая төгрөгийн 566 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт батлагдаж, нийт 18,491.7 сая төгрөгийн 195 ажлын гүйцэтгэчийг нээлттэй болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 6,742.0 сая төгрөгийн 464 шууд гэрээ байгуулжээ.

Хүснэгт №3: Төв аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа

№	ОНХС-ийн нэр	ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээ		Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан					
				Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	27 сумын дүн	480	19,153,305.6	30	5,280,829.1	107	4,849,065.2	221	4,408,570.3
2	Төв аймаг ОНХС	86	13,281,230.2	41	7,321,915.9	17	1,039,943.8	125	2,333,472.6
	Нийт дүн	566	32,434,535.8	71	12,602,745.0	124	5,889,009.0	346	6,742,042.9

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 сарын 04-ний өдрийн ээлжит бус 6 дугаар хуралдааны 02 тоот тогтоолоор хөрөнгө оруулалтын ажлуудыг тодотгож батлахдаа, зарим ажлын төсөвт өртгийг хэд хэд хувааж баталжээ. Тухайлбал:

- Цагдаа, олон нийтийн төв, нийтийн бие засах газрын засварын 59.0 сая төгрөгийн ажлыг 3 хувааж,
- Нэгдсэн эмнэлгийн уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх явган зам талбай байгуулах 50.2 сая төгрөгийн ажлыг 3 хувааж,
- 1000 айлын урд хэсэгт автозамын коридор гарган, автозамын талбайг тэгшилж хусах, хайргаар далангийн дүүргэлт хийх 38.5 сая төгрөгийн ажлыг 2 хувааж,
- Усан оргилуурын гэрэлтүүлгийн засварын 34.2 сая төгрөгийг 2 хувааж,
- САХ-нийн баруун урд хэсэгт хөрс хуулж, хайрга дэвсэн авто зогсоол байгуулах 29.9 сая төгрөгийг 2 хувааж,
- 9,10-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн 142.5 сая төгрөгийн ажлыг 3 хуваасан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаа нь:

- Он дамжин хэрэгжсэн 566.2 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ

- Тайлант онд хэрэгжээгүй 145.3 сая төгрөгийн 3-аас бусад шинээр хэрэгжих 79 ажилд зохион байгуулагджээ. Үүнд:
- Нээлттэй тендер шалгаруулалтаар 7,379.7 сая төгрөгийн 32 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас 7,229.6 сая төгрөгийн 41 ажлын,
 - Харьцуулалтын аргаар 1,273.9 сая төгрөгийн 21 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас 1,039.9 сая төгрөгийн 17 ажлын,
 - Шууд худалдан авалт буюу шууд гэрээгээр 469.2 сая төгрөгийн 29 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаас 707.8 сая төгрөгийн 32 ажилд гэрээ байгуулжээ.
- Ойн бүтээн байгуулалтын ажлын 3,500.0 сая төгрөгөөр хэрэгжсэн ажлууд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, 4,101.6 сая төгрөгийн 212 шууд гэрээ байгуулагдсан байна.

Хүснэгт №4 :Аймгийн ОНХС-ийн худалдаа авах ажиллагаа
/ИТХ-аар батлагдсан төсөвт өртгөөр/

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа	Он дамжин хэрэгжсэн ХО болон хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ		НТШ		ХА		Шууд		Дүн	
	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн
Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсөвт өртгөөр	3	566,197.6	32	7,379,695.9	21	1,273,868.8	29	469,167.9	85	9,688,930.2
								3,500,000.0		3,500,000.0
ХАА гүйцэтгэлээр /гэрээний дүн/	6	711,535.5	41	7,229,615.9	17	1,039,943.8	32	707,835.0	96	9,688,930.2
							212	4,101,632.3	212	4,101,632.3

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Зарим хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг аймгийн ИТХ-аас баталсан төсөвт өртгөөс нэмэгдэж, хандивын орлогоос шууд гэрээ байгуулснаас гадна, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудыг жижиглэн хувааж шууд гэрээ байгуулжээ. Хурлын тогтоолоор батлагдсан 13,281.2 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийн 8,269.5 сая төгрөгийн 58 ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, үлдсэн 5,011.7 сая төгрөгийн 243 гэрээг шууд байгуулжээ.

Аудитаар аймгийн ОНХС-аас хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. /Хавсралт 2/ Үүнд:

- Аймгийн ИТХ-аар ой угтсан бүтээн байгуулалтын ажилд бөөн дүнгээр жагсаалтгүй 3,500,0 сая төгрөг баталсан боловч хандиваар 1,995.4 сая төгрөг орсон хэдий ч 4,101.6 сая төгрөгийн 212 шууд гэрээ байгуулсан.
- Хурлын тогтоолоор батлагдсан 3,671.4 сая төгрөгийн төсөвтэй 16 хөрөнгө оруулалтын ажлын баталсан төсвийг 1,447.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,118.7 сая төгрөгийн 116 гэрээ байгуулснаас 98 гэрээ нь шууд байгуулагдсан байна. Үүнд:

- 101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах 142.5 сая төгрөгийн ажлыг 10 шууд гэрээгээр,
 - 2 талтай LITEBOX самбар худалдан авах, самбаруудыг зөөх, суурилуулах, өнгө сэрээх, засварын ажлын 30.0 сая төгрөгийн ажлыг 2 гэрээгээр,
 - 9-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайд 142.5 сая төгрөг батлагдсан боловч 181.7 сая төгрөгийн 6 гэрээ байгуулагдсаны 118.4 сая төгрөгийн ажилд нээлттэй тендер зарлаж үлдсэн 63.3 сая төгрөгийн ажилд 5 шууд гэрээ,
 - Төв-100 дөрвөлжин болон дугуй хэлбэртэй гэрэлт самбар хийх, гэрлийн шонд суурилуулах /Зуунмод сум/ ажлын 157.1 сая төгрөгийн ажлыг 2 хувааж ТИЙМ ЭТТЭ ХХК-тай 11 сард 2 гэрээ байгуулсан. Тус ажлын тендер 11 сард зарлагдаж гэрээ байгуулагдсан нь өмнө хийгдэж гүйцэтгэл нь гарсан ажилд тендерийн бичиг баримтыг нөхөн бүрдүүлсэн байна.
 - Мөнх-Алдын талбайг шинэчлэн засварлах /хавтан худалдан авах, суулгах, цемент элс хайрга зөөвөрлөх, цутгалт хийх/ ажилд 527.5 сая төгрөгийн 7 гэрээ байгуулагдсанаас 400.0 сая төгрөгийн ажилд нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж, үлдсэн 127.7 сая төгрөгийн ажлыг 6 хувааж шууд гэрээ,
 - Өв соёлын өргөө цогцолбор байгуулах ажилд 1,150.1 сая төгрөг батлагдаж, 1,525.6 сая төгрөгийн 33 гэрээ байгуулагдсанаас 973.9 сая төгрөгийг 6 гэрээг нээлттэй тендерээр, үлдсэн 552.0 сая төгрөгийн ажлыг 27 шууд гэрээ,
 - Гэрийн суурь дүүргэлт зуурмаг нийлүүлэх 150.1 сая төгрөгийн ажлыг 117.0 сая төгрөг, 33.0 сая төгрөгөөр 2 хувааж шууд гэрээ,
 - Нэгдсэн эмнэлгийн уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх явган зам талбай байгуулах 56.7 сая төгрөгийн ажлыг 4 шууд гэрээ,
 - Одонт хөтлийн шинэчлэлийн 131.6 сая төгрөгийн ажлыг 8 шууд гэрээ,
 - Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар шинэчлэлийн ажилд 1,019.5 сая төгрөг батлагдаж 1,295.3 сая төгрөгийн 27 гэрээ байгуулагдсанаас 989.5 сая төгрөгийн 4 ажилд нээлттэй тендер зарлагдаж, үлдсэн 305.8 сая төгрөгийн ажилд 23 шууд гэрээ байгуулагджээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Сумын төвийн гэрэлтүүлэг тохижилт төсөл/ Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр/-ийн 480.0 сая төгрөгийн өртөгтэй шинээр хэрэгжиж буй ажлын төсвийг төсөвчний эрхгүй хүнээр хийлгэж, баталгаажаагүй төсвөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулсан. Энэ нь Барилгын тухай хуулийн 24.2-т "Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр

санхүүжүүлэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна" гэсэн заалтыг зөрчсөн.

Аймгийн 27 сумын ИТХ-аар сумын ОНХС-ийн хөрөнгөөр 19,592.3 сая төгрөгийн 468 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдаж, 5,280.8 сая төгрөгийн 30 ажилд нээлттэй тендер, 4,869.3 сая төгрөгийн 108 ажил харьцуулалтын аргаар зохион байгуулагдаж, 4,390.1 сая төгрөгийн 220 шууд гэрээ байгуулагдсан байна. Сумууд ОНХС-ийн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Аймгийн ОНХС-аас эрх шилжиж хэрэгжсэн 44.0 сая төгрөгийн Зуунмод сумын Зүүндэлгэр багийн хүчдэлийн уналттай өрхийн 0.4 кВ-ын ЦДАШ-ын өргөтгөл хийх ажил 2023 оны анхны төсөв батлагдсан тогтоолоор батлагдсан боловч 12 сард тендер зохион байгуулах хугацаагүй гэдэг шалтгаанаар шууд гэрээ байгуулжээ.

- Баянхошуу, Зүүндэлгэр, Баруун Зуунмод багийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан, дулааны шугам сүлжээний зураг, төсвийг 1,283.7 сая төгрөгөөр ЭХҮТ-өөс баталгаажуулсан байна. Зураг, төсвийг 40.1 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд нийт ХО-ын ажлын төсөвт өртөгт зураг, төсвийн үнэ 40.1 сая төгрөгийг оруулж тооцолгүй 1,283.7 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.15-д "Төслийн гэрээнд барилга угсралтын дүн, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт зардлыг нэг бүрчлэн тусгахаас гадна тухайн гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай заалтыг тусгасан байна", 4.1.16-д "Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгын үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэг бүрчилсэн төсвийн зардлыг тооцно" гэсэн заалтуудыг зөрчсөн.
- Эрдэнэсант сум ойн тэмдэглэх бэлэг дурсгалын зүйл худалдан авахдаа шууд худалдан авалт хийх зорилгоор босго үнэд /20.0 сая төгрөг/ багтаах зорилгоор иргэнтэй 15.9 сая төгрөгийн гэрээг 2 удаа хийсэн, нийт гэрээний 31.7 сая төгрөг болсон байна.

Аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудын төсөвт өртөг нэмэгдсэн, худалдан авах ажиллагаа явуулалгүй гэрээ шууд байгуулж байгаа нь зураг, төсөвгүй ажлууд батлагдсанаас шалтгаалсан байна.

Аймаг, сумын ОНХС-аас 32,434.5 сая төгрөгийн 566 төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажилд 28,532.8 сая төгрөгийн 540 гэрээ байгуулагдаж 25,852.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №5: Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл

№	ОНХС-ийн нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын тоо		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		/мян.төг/ Санхүүжилт
		тоо	дүн	тоо	дүн	
1	27 сумын дүн	480	19,153,305.6	364	15,277,633.3	12,969,794.3
2	Аймгийн ОНХС нийт	86	13,281,230.2	304	13,255,221.1	12,882,286.0
	Үүнээс: төсөвт өртгийг баталсан	85	9,781,230.2	91	9,153,588.7	8,777,926.2
	Хурлаас баталсан төсөвгүй	1	3,500,000.0	213	4,101,632.3	4,101,359.8
	Нийт дүн	566	32,434,535.8	668	28,532,854.4	25,852,080.3

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Аймгийн ОНХС-ийн санд нийт 13,255.2 сая төгрөгийн 304 гэрээ байгуулагдаж, 12,882.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Улсын төсвийн санхүүжилтээр 9,781.2 сая төгрөгийн 85 ажилд 9,466.4 сая төгрөгийн 92 гэрээ байгуулагдаж, 8,777.9 сая төгрөгийн санхүүжилт, хандив, тусламжаар 1,995.4 сая төгрөгийн орлого орсон боловч 4,101.6 сая төгрөгийн 212 гэрээ байгуулагдаж 4,104.4 сая төгрөгөөр санхүүжигдсэн байна.

Хүснэгт №6: Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт

№	Төсөл арга хэмжээ	Батлагдсан				Хэрэгжсэн			/мян.төг/
		Тоо	Ажлын тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Ажлын тоо	Гэрээний дүн	Санхүүжсэн	
1	Шилжих үлдэгдлээс	4	4	527,643.8	307,300.7	4	478,492.7	291,868.7	
2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	11	15	2,444,000.0	2,444,000.0	13	2,237,631.9	2,201,584.3	
3	Шинээр хийгдэх их засварын ажлууд	42	42	3,233,186.4	3,140,886.4	41	3,083,980.9	3,033,753.1	
4	Бусад төсөл арга хэмжээ	8	24	3,576,400.0	3,574,229.2	34	3,353,483.3	3,250,720.1	
	ДҮН	65	85	9,781,230.2	9,466,416.3	92	9,153,588.7	8,777,926.2	
5	Аймгийн 100 жилийн ой угтсан бүтээн байгуулалтын болон бусад хандив тусламжийн орлого	1	1	3,500,000.0	3,500,000.0	212	4,101,632.3	4,104,360.7	
	БҮГД	66	86	13,281,230.2	12,966,416.3	304	13,255,221.1	12,882,286.9	

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Аудитаар Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аймгийн ИТХ-аар батлагдсан 13,281.2 сая төгрөгийн 86 хөрөнгө оруулалтын ажилд 13,255.2 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 12,882.3 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ. Хандивын орлогоор 3,500.0 сая төгрөгөөр ой угтсан бүтээн байгуулалтын ажилд зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч, 1,995.4 сая төгрөгийн орлого орсон байхад 4,101.6 сая төгрөг буюу батлагдсан санхүүжилтээс 601.6 сая төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 25.6-д "Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Хандив тусламж, аймгийн төсвийн эх үүсвэрээр ой угтсан ажилд 4,101.6 сая төгрөг зарцуулснаас 1,625.6 сая төгрөг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд зарцуулж, 2,476.0 сая төгрөг баяр наадмын үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; 42 дугаар зүйлийн 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг тус тус зөрчсөн.
- Зуунмод сумын 18-р байрны дээврийн хэсэгчилсэн засварын ажлын 127.6 сая төгрөгийн зардлын 41.9 сая төгрөгөөр нь нэг айлын буюу иргэний орон сууцыг засварласан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын жагсаалтын 3.6-д Нийтийн тээвэр төсөл хэрэгжүүлэх зардалд 737.8 сая төгрөг баталснаас 525.4 сая төгрөгөөр 2 ширхэг автобус, смарт картын тоног төхөөрөмж, автобусны буудлын сүүдрэвч хийж, 135.9 сая төгрөгийг жолоочийн цалин, түлш шатахуун, гражийн түрээс зэрэг урсгал зардалд зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; 42 дугаар зүйлийн 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг тус тус зөрчсөн.
- Аймгийн Засаг даргын 2023 оны А/477 тоот захирамжаар Цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажлын зардал 11.8 сая төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээгүй, гүйцэтгэл гараагүй, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн мэдэгдэлгүй, урсгал зардлаас шууд зарцуулсан байна. Энэ нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4

дүгээр зүйлийн 4.8.12-д "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох..." гэсэн заалтыг зөрчсөн.

- Аймгийн Засаг даргын 2023 оны А/316, А/317 тоот захирамжаар Ж.Мөнхбат, Д.Хадбаатар аваргын хөшөө бариулах гэрээг иргэнтэй мөнгөн дүнгүй байгуулж, 30.0 сая төгрөг шилжүүлсэн, одоо хүртэл хийгдээгүй. Энэ нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4 дүгээр зүйлийн 4.8.12-д "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно" гэж заасныг зөрчсөн.
- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд бус төсөвт байгууллага болох ОБГ, Зэвсэгт хүчний 016-р анги зэрэг газруудад ажлын хөлс, номын үнэ, хөшөөний ажлын хөлс зэрэг 49.5 сая төгрөг шилжүүлсэн нь холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй.

Сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Зарим сумд ажлын гүйцэтгэл гараагүй, гэрээнд заасан ажил эхлэх хугацаа болоогүй байхад урьдчилгаа санхүүжилтийн баталгаагүй 50-100 хувийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон байна. Үүнд: Алтанбулаг, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Баянцогт, Борнуур, Баянхангай, Зуунмод, Сүмбэр, Угтаалцайдам сумд
- Батсүмбэр сум 2023 оны хөрөнгө оруулалтын зураг төсөв гэж батлагдсан 30.0 сая төгрөгөөс ЗДТГ-ын засварын зураг төсөв 4.0 сая төгрөгөөр хийлгэх гэрээ байгуулж 2.0 сая төгрөг шилжүүлсэн, Гамшгаас хамгаалах гэж ерөнхий нэртэй батлагдсан арга хэмжээнээс 2 иргэнд тус бүр 0.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
- Баяндэлгэр сум ИТХ-аар батлагдаагүй гадна гэрэлтүүлгийн ажилд 12.0 сая төгрөг зарцуулсан.
- Баян-Өнжүүл сум нь Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах төслийн хүрээнд Флай хай ХХК-тай 170.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдөр ашиглалтад хүлээж авах байсан. Гэвч 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрийг хүртэл хүлээж аваагүй гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаа хэтэрсэн байна.
- Баян-Өнжүүл сумын хүүхдийн цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилтын ажилд 2023.10.10-ны өдөр 16.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2024 оны 07-р сарын 4-ний өдөр хүртэл ямар ч ажил хийгдээгүй байна.
- Баян өнжүүл сумын баяр наадмын талбайн тохижилтын 90.0 сая төгрөгийн гэрээт ажилд ажлын гүйцэтгэл гараагүй байхад 80% буюу 72.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Баянхангай суманд 90.0 сая төгрөгийн гэрээтэй ТАХ-ын орон сууц хэрэгжүүлэхэд аймгийн ОНХС-аас 90.0 сая төгрөгийн санхүүжилтийг 2023 оны 10 сарын 04-нд сум руу шилжүүлжээ. Сумын Засаг даргын орлогч нь гүйцэтгэгчид 90.0 сая төгрөгийн санхүүжилт олгох захирамж гаргаж, 2023 оны 10 сарын 25-нд 72.0 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээнд заасан ажил эхлэх хугацаа болоогүй байхад өгчээ. Тухайн барилгын ажлыг өвлийн улиралд хийхээр

гэрээ байгуулж, өнөөдрийн байдлаар хэрэгжиж дуусаагүй, гэрээний хугацаа хэтэрсэн байна.

- Өндөрширээт сум нь уурын зуухны гадна фасадыг засварлаж өвс тэжээлийн фонд болгох ажлын 50 хувиар буюу 28.0 сая төгрөг, нэгдсэн хогийн цэгийг ланд филлийн аргаар булшлах ажлын санхүүжилтийн 70 хувь буюу 42.0 сая төгрөг нийт 70.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэл гараагүй байхад урьдчилж олгосон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл гараагүй байхад их хэмжээний урьдчилгаа санхүүжилт олгосон зэрэг нийтлэг зөрчлүүд илэрлээ.

2.2. Сум, орон нутагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чанартай бус олон жижиг ажлууд нь төлөвлөж, хэрэгжүүлж байгаа ОНХС-ийн хөрөнгө үр өгөөж, ач холбогдлыг бууруулж байна.

Тайлант хугацаанд аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаас нийт 28,532.9 сая төгрөгийн 540 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсанаас 25,547.0 сая төгрөгийн 615 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсон байна. Эдгээр ажлууд нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй үндэслэсэн, сумын иргэдийн саналыг эрэмбэлэн хэрэгжүүлсэн тул төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн гэж үзэж болохоор байна.

Сум, орон нутагт гэрээ шууд байгуулж хэрэгжсэн олон жижиг ажлууд нь ОНХС-ийн хөрөнгө үр өгөөж, ач холбогдол багатай зарцуулагдаж байна гэж дүгнэхээр байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлж, Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр, спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах, Нийтийн тээвэр - Зуунмод төсөл, 100 өрх - 100 гэр төсөл, цахилгааны эрчим хүчний өргөтгөл, дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний их засвар, өргөтгөл, шинэчлэл, гэрэлтүүлэг, авто зогсоол, нийтийн бие засах газар зэрэг ажилд хөрөнгө төлөвлөгдөж хэрэгжүүлсэн байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бүрэн хэрэгжиж дууссан 25,547.0 сая төгрөгийн 615 хөрөнгө оруулалтын ажил байгаагаас 12,341.8 сая төгрөгийн 313 нь сум, орон нутагт, 13,205.2 сая төгрөгийн 302 хөрөнгө оруулалт нь аймгийн ОНХС-аас хэрэгжиж, зориулалтын дагуу бүрэн ашиглагдаж байна. Тухайлбал:

Дэд бүтцийг нэмэгдүүлэх, сайжруулахад

- Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Баянхангай, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянжаргалан/ 400.0 сая төгрөгийн ажлыг 5 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж, Баянжаргалан сумаас бусад 4 суманд 303.4 сая төгрөг,

- Зуунмод сумын нийтийн 7 орон сууцны төв магистрал шугам сүлжээнүүдийг шинэчлэх ажилд 220.0 сая төгрөг төлөвлөж, 208.0 сая төгрөг,
- Эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх Батсүмбэр, Зуунмод суманд 144.0 сая төгрөг төлөвлөж, 142.3 сая төгрөг,
- Сумын төвийн гэрэлтүүлэг шинэчлэл /Мөнгөнморьт, Зуунмод, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр/ 1,040.0 сая төгрөг төлөвлөж, 982.4 сая төгрөг.

Нийтийн эзэмшлийн болон явган зам талбайн тохижилтод:

- Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоонд /Баяндэлгэр, Баян Өнжүүл, Баянцагаан, Баянцогт, Заамар, Зуунмод, Лүн, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ/ 10 суманд 600.0 сая төгрөг төлөвлөж, 651.5 сая төгрөг,
- Төвийн авто зам дагуу явган хүний зам барилгын ажил /Зуунмод сум/ 400.0 сая төгрөг төлөвлөж, 350.9 сая төгрөг.

Мөн сум орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор “Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал”-д 7 суманд 700.0 сая төгрөг төлөвлөж, 684.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд аймгийн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан шинээр 27 сум, аймгийн хүндэтгэлийн арга хэмжээнд зориулж 1,711.8 сая төгрөгөөр “Өв соёлын өргөө” цогцолборыг бүтээн байгуулж, хуучин ашиглагдаж байсан Мөнх алдрын талбайг шинэчлэн засварлах, тохижуулахад 527.5 сая төгрөг, Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, шинэчлэлд 1,295.3 сая төгрөгөөр тохижилт, хөрөнгийн сайжруулалтын ажлыг хийсэн байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг удирдлага мэдээллийн системд бүрэн тайлагнаагүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасны дагуу Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Дотоод аудитын хорооны даргын баталсан 33/45 тоот удирдамжийн дагуу 27 сумын ОНХС-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтыг 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтад тулгуурлан шалгаж үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна дараах чиглэлээр тодотгож хийсэн байна. Үүнд:

- Төсвөөс олгогдсон санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалт, үр ашиг
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн тайлан мэдээ гаргалтын байдал
- Худалдан авах үйл ажиллагаа, тендер зохион байгуулалт

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглалт, хамгаалалт, орлогод авсан байдал
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж буй эсэхийг тус тус хамруулан шалгасан байна. Хяналт шалгалтаар нийт 248.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж акт албан шаардлага өгөгдсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд 27 сумаас 5 сумын ИТХ хяналт шалгалтыг хийсэн. Үүнээс Баянчандмань, Зуунмод сумд ИТХ-ийн хяналтын хороог байгуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд хяналт шалгалт хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж, иргэдэд мэдээлж ажилласан байна. Бусад 22 сумын ИТХ-ын дэргэдэх хороод хяналт шалгалтыг хангалтгүй хийсэн байна. Мөн аймгийн ОНХС-ийн гүйцэтгэлээр 66 төсөл арга хэмжээд 13,281.2 сая төгрөгийг баталж гүйцэтгэлээр 86 төсөл арга хэмжээнд 12,882.2 сая төгрөгийг зарцуулсан байна. ИТХ-ын дэргэдэх хороод 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Хавсралт 3/

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт харилцан адилгүй хэрэгжиж байна. Батсүмбэр суманд захиалагчийн хяналт хэрэгжсэн, ажил бүрд ажлын хэсэг гаргаж хяналтыг тавьж ажилласан, мөн төсөвт өртөг харьцангуй их наадмын талбай шинэчлэх ажилд БЗОСК-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бол Архуст, Баян, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Заамар сумдад захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна.

Захиалагч нь “Барилгын тухай хууль” болон “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-д заасны дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Үүний дагуу аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн нийт 10,406.2 сая төгрөгийн 85 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Харин сумдад 12,969.7 сая төгрөгийн 376 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс 12,113.6 сая төгрөгийн 313 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. 1,644.9 сая төгрөгийн 63 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй бөгөөд энэ нь урсгал зардлыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна. /Хавсралт 4/

Өмнөх буюу 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитаар аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Ю.Бямбацогт нарт дараах зөвлөмжүүд өгөгдсөн байна.

- Аймгийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөхдөө Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн өгсөн саналыг хөрөнгө, оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад тусгах талаар арга хэмжээ авч ажиллах.

- “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд заасан ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлэх, хяналт тавьж ажиллах.

Сумдын Засаг дарга нарт

- Сумдын ОНХС-ийн эх үүсвэрт хуульд заасан малын тоо толгойн албан татварыг тооцон төлөвлөж, хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 07/66 албан бичгээр ирүүлсэн. Аудитаар дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 1-р зөвлөмжөөс Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 7.5-д урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна гэсэн ажил хийгдээгүй, 2-р зөвлөмжийн хэрэгжилт 41.0 хувтай, 3-р зөвлөмжийн хувьд Зуунмод сумаас бусад сумдын хувьд хэрэгжсэн байна.

3.2. ОНХС-ийн сангийн удирдлага мэдээллийн системд 5,103.8 сая төгрөгийн 159 төсөл арга хэмжээ буюу 41.03 хувийг огт мэдээлээгүй байна.

ОНХС-ийн журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.” гэж заасны дагуу холбогдох мэдээллийн дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

Сумдын хувьд тухайн онд 12,969.7 сая төгрөгийг холбогдох төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Үүнээс 1,933.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Аймгийн ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын данс бүртгэлд тусгасан эсэх талаарх холбогдох баримт материалыг ирүүлээгүй тул тулган баталгуулах боломжгүй байна.

ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахдаа хууль журамд заасны дагуу иргэдийн саналыг авч буй эсэхэд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг бий болгох, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор УМС-ийг ашиглаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулагч шат шатны албан хаагчид мэдээлэл оруулахад зориулагдсан байдаг. Төлөвлөлт нь иргэний гаргасан саналуудаас эхлээд Иргэдийн нийтийн хурлаар хэдэн санал, хэрхэн эрэмбэлэгдсэн, түүнийг ажлын хэсэг яаж нэгтгэж, эрэмбэлсэн, цаашлаад Иргэдийн төлөөлөгчийн хурал хэрхэн баталсан гээд анх санал гарахаас эхлээд ИТХ-аар батлагдах хүртэлх мэдээллийг дэлгэрэнгүй оруулах цэс юм. Аудитын явцад шалгахад сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 480 төсөл арга хэмжээнд 19,153.3 сая төгрөгийг баталсан байна. Үүнээс ОНХС-ийн сангийн удирдлага мэдээллийн системд 13,115.0 сая төгрөгийн 276 төсөл арга хэмжээ буюу 58.9 хувийг бүрэн оруулж мэдээлсэн байна. 1,352.8 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээ буюу 0.07 хувийг дутуу, 5,103.8 сая төгрөгийн 159 төсөл арга хэмжээ буюу 41.03 хувийг огт мэдээлээгүй байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08

дугаар сарын 04-ны өдрийн ээлжит бус 6-р хуралдаанаар ОНХС-ийн 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийн жагсаалтыг баталсан байна. Нийт 66 төсөл арга хэмжээний 86 ажилд 13,281.2 сая төгрөг төсөвлөгдсөн бөгөөд дээрх батлагдсан төсөл арга хэмжээг ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд байршуулж иргэд олон нийтэд мэдээлээгүй зөрчил байна. /Хавсралт 5/

Төсвийн ерөнхийлөн захирагч болон төвлөрүүлэн захирагчид “Шилэн дансны тухай хууль” болон “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг тухай бүр мэдээлэх үүрэгтэй.

ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсныг шалгаж үзэхэд аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор мэдээлбэл зохих нийт 533 төсөл арга хэмжээнд 32,454.6 сая төгрөгийг баталсан байна. Үүнээс 404 төсөл арга хэмжээний 28,694.8 сая төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулж, 129 төсөл арга хэмжээний 3,759.8 сая төгрөгийн мэдээллийг огт байршуулаагүй зөрчил байна. Мөн тухай бүр мэдээлбэл зохих саруудын мэдээллийг хоцроож мэдээлсэн байна. /Хавсралт 6/

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэд нарт зөвлөх нь:

- Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 7 дугаар зүйлийн 7.5-д заасан урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ОНХСийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулж ажиллах,

Зуунмод сумын Засаг дарга Ч.Сарангэрэлд:

- Малын тоо толгойн албан татвараар орлогыг төлөвлөж, ОНХС-ийн эх үүсвэрт төвлөрүүлэн холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллах.

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Аудитын менежер О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

Аудитор Ч.Загдсүрэн

Аудитор Б.Одбилэг

НХА0064 9060484

Холбогдох байгууллагын санал:



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номо-1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tav_zdiga@rov.gov.mn

2024.07.25 № 07/257

танай _____ ны № _____


ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналтай асуудлуудад тайлбар хүргүүлснийг харгалзаж үзэхийг хүсье.

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах болно.

ХӨГЖЛИЙН БОЛЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ Д.САРАН-ЭРДЭНЭ



4107741292



ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зүүнмөрөн сум
Утас: 70272262, Факс: 70272192

2024.04.25 № 07/682
Тайлан - илт №

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд
хийсэн аудитын тайлантай танилцлаа.
Аудитын тайланд өгөх саналгүй болно.

ДАРГА

Б.НАСАНЖАРГАЛ

2024.04.25
My doc: Toot A5




**ТӨВ АЙМАГ
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨЛАТҮГ**

41100 Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272640

2024.07.25 № 199
Төрийн аудитын газарт

**ТӨВ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”
гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.
Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ  Ж.БАТТОГС


My com. D disc A5 тоот / 2024/

4124000325

Хавсралт 1

ОНХС-нд олгох орлогын шилжүүлгийг тооцсон аргачлал

/мян.төг/

№	Сум	Алслалтын индекс	Хүн амын тоонд жинлэсэн алслалтын индекс	Итгэлцүүрийн хуваарилалт				Урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /сумдад хуваарилах суурь 50 хувь/	Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
				Алслалтаас хамаарах 30%	Хүн амын тооноос хамаарах 40%	Нутаг дэвсгэрээс хамаарах 30%	Итгэлцүүр нийт дүн				
1	Алтанбулаг	0.195402	646.4	40,037.3	128,871.6	209,782.7	378,691.6	51,411.9	-	6,753.8	436,857.2
2	Аргалант	0.501916	803.6	49,772.8	62,371.0	41,799.9	153,943.7	21,517.3	-	-	175,461.0
3	Архуст	0.432950	582.8	36,095.5	52,436.9	30,773.7	119,306.1	-	1,488.1	795.3	121,589.4
4	Батсүмбэр	0.467433	3,290.7	203,827.0	274,261.2	90,221.1	568,309.3	77,494.5	-	-	645,803.8
5	Баян	0.298851	612.3	37,928.5	79,824.0	107,815.4	225,568.0	31,901.8	4,094.5	97,923.7	359,487.9
6	Баяндэлгэр	0.413793	661.2	40,957.2	62,254.2	79,659.5	182,870.8	-	1,682.4	19,217.4	203,770.5
7	Баянжаргалан	0.551724	908.7	56,284.0	64,163.1	88,193.0	208,640.1	28,416.1	4,181.8	113,323.2	354,561.2
8	Баян-Өнжүүл	0.501916	1,107.2	68,581.3	85,940.4	177,795.1	332,316.8	45,441.4	4,937.0	26,702.0	409,397.1
9	Баянхангай	0.586207	821.9	50,906.0	54,618.5	37,382.3	142,906.8	-	-	-	142,906.8
10	Баянцагаан	0.429119	796.9	49,358.2	72,344.2	240,259.5	361,961.9	-	1,500.4	5,743.6	369,205.9
11	Баянцагт	0.528736	907.8	56,231.4	66,890.1	54,625.6	177,747.1	31,271.6	913.9	20,816.8	230,749.3
12	Баянчандмань	0.425287	1,798.1	111,374.9	164,712.5	22,754.2	298,841.6	80,550.8	756.1	3,163.3	383,311.8
13	Борнуур	0.551724	2,759.7	170,936.7	194,865.7	42,560.7	408,363.1	57,070.8	552.7	6,220.7	472,207.3
14	Бүрэн	0.735632	2,179.7	135,008.8	115,431.2	139,434.5	389,874.6	54,851.4	41.7	17,402.7	462,170.4
15	Дэлгэрхаан	0.942529	1,712.6	106,076.5	70,785.9	80,456.2	257,318.6	-	2,043.0	7,858.8	267,220.4
16	Жаргалант	0.655172	4,420.4	273,801.6	262,846.6	69,323.2	605,971.4	97,609.9	779.2	10,694.8	715,055.3
17	Заамар	0.865900	5,084.6	314,937.0	228,758.8	104,356.8	648,052.5	-	41.1	174,682.0	822,775.5
18	Зуунмод	0.000000	-	-	674,472.1	711.8	675,183.9	108,544.5	-	-	783,728.4
19	Лүн	0.670498	1,690.3	104,696.4	98,212.0	93,872.4	296,782.8	41,141.1	7,067.0	838.9	345,829.8
20	Мөнгөнморьт	0.743295	1,667.2	103,266.7	87,381.8	249,404.6	440,053.1	57,943.3	-	1,688.5	499,684.8
21	Өндөрширээт	0.885057	1,786.0	110,627.3	78,616.3	100,858.7	289,902.4	39,518.3	809.5	-	330,230.2
22	Сүмбэр	0.789272	-	-	87,630.3	12,962.6	80,592.9	23,321.1	4,357.0	5,435.1	113,706.1
23	Сэргэлэн	0.053640	111.8	6,924.0	81,187.5	143,458.8	231,570.3	-	2,545.1	21,137.5	255,252.8
24	Угтаалцайдам	0.762452	2,012.1	124,629.7	102,809.0	57,442.7	284,881.4	39,382.4	640.3	-	324,904.0
25	Цээл	0.850575	2,251.5	139,455.7	103,120.6	81,483.2	304,039.5	48,934.8	733.2	-	353,707.4
26	Эрдэнэ	0.318008	1,255.8	77,784.7	153,843.4	296,342.3	529,970.5	72,392.9	871.7	16,049.2	619,284.2
27	Эрдэнэсант	1.000000	4,492.0	278,233.5	174,997.3	112,224.2	565,455.0	151,400.5	-	-	716,855.5
Нийт			44,361.4	2,747,734.7	3,663,646.3	2,747,734.7	8,159,116.7	1,160,116.4	40,835.2	866,446.9	10,916,714.1

Хавсралт 2

Аймгийн ОНХС-ийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа

/мян.төг/

№	Төсөл арга хэмжээ	Баталсан төсөвт өртөг	Төндөр			Гэрээний дүн	Гүйцэтгэгч
			НТШ	ХА	ШГ		
1	1000 айлын урд хэсэгт автозамын коридор гарган, хайрган хучилттай зам тавих /301 байр, 640 хүүхдийн сургууль/	38,525.2			2	38,525.3	Гоц тех инженеринг ХХК
2	101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах				10	142,528.9	
2.1	101-р байрны орчмын тоглоомын талбайн гадна гэрэлтүүлгийн ажил				1	12,349.9	Төв гэрэл ХХК
2.2	101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, үсэг байршуулах байрлалд явган замын хавтан, хашлага суулгах зардал				3	44,475.6	Түвшинтөгсийн Гүрбазар, ОБГ, "Тэнгэрийн долоон од" ХХК
2.3	I love TUV суурилуулах				1	5,900.0	Очирарвай төв ХХК
2.4	101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайд саравч, сандал суурилуулах, материал худалдан авах				2	23,994.0	Иргэн Э.Дашдорж, Уудам өсөх ХХК
2.5	101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайд тоглоом суурилуулах, газар шорооны ажил				2	39,859.4	Буман заг ХХК
2.6	101-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн хашаа суурилуулах				1	15,950.0	Гэрэгэ прожект ХХК
3	2 талтай LITEBOX самбар худалдан авах, самбаруудыг зөөх, суурилуулах, өнгө сэргээх, засварын ажил				2	30,018.0	Жи Эй Эф Эй ХХК, Төв плас ХХК

4	9-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн ажил	142,529.2	1	-	5	181,736.2	
4.1	9-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн гэрэлтүүлгийн ажил	11,944.8			1	11,944.8	МЕСА ИНЖЕНЕРИНГ ХХК
4.2	9-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн ногоон байгууламжийн ажил	12,301.0			1	12,301.0	ЗУУНМОД Цэцэрлэгжүүлэлт
4.3	9-р байрны орчмын хүүхдийн тоглоомын талбайн сагсны талбай, леги талбай байгуулах /цутгах, өнгөлөх, газар шороо, тоглоомын зардал/	118,443.4	1		3	157,490.3	ТЭНГЭРИЙН ДОЛООН ОД, Люксландшафт ХХК, УРГАМАЛЫН ДАЛАЙ ХХК, Буман заг ХХК,
5	Төв зам дагуу гэрэлтүүлгийг баяр наадмын туг далбаагаар чимэглэх				3	25,947.6	"Төв гэрэл" ХХК, "Том ноёд" ХХК, "Клотинг лаб" ХХК
6	төв-100 дөрвөлжин болон дугуй хэлбэртэй гэрэлт самбар хийх, гэрлийн шонд суурилуулах / Зуунмод сум/			2		157,100.0	ТИЙМ ЭТТЭ ХХК
7	Мөнх-Алдрын талбайг шинэчлэн засварлах /хавтан худалдан авах, суулгах, цемент элс хайрга зөөвөрлөх, цутгалт хийх/	459,925.0	1		6	527,469.2	Төв АЗЗА ТӨХК-2, Тусгал төв ХХК, Би Би Жи Поккет ХХК-2, Ворлд грийн плант ХХК, Монгол Эф Пи ХХК
8	Зуунмод сумын зөөврийн ОО /бие засах газар/-ын угсрах, тохижилтын ажил				2	30,000.0	"ОБМА" ХХК, ОЛОН УЛСЫН НҮҮДЭЛЧИН АЯЛАЛ
9	Өв соёлын өргөө цогцолбор байгуулах ажил	1,150,080.0	6	-	27	1,711,852.2	
9.1	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал-Цахилгаан, гэрэлтүүлгийн ажил, гэрэлтүүлэг худалдан авах	139,427.7	1		3	183,138.7	Багц-1: Төв гэрэл ХХК-3, АРВАЙН БӨГЭЭ ХХК

9.2	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал-гэр нийлүүлэх, паркет, террасны шал, холбогч худалдан авах, суурилуулах	296,917.0	1		5	396,317.0	Багц-2: Уянгын гурван эрдэнэ ХХК, ОЛИМПИК КОТИНОС, Олбфрэнд, "Тэнгэрийн долоон од" ХХК-3
9.3	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал-28 гэрийн суурь, шат довжоо цутгах,				10	296,804.8	Цээцээ Манхан ХХК, "Ар булаг" ХХК, "Төв гэрэл" ХХК, Очир -Арвай ХХК, "Есөн хэлхээ" ХХК, "Азу майнинг" ХХК
9.4	Багц-3: Цээцээ Манхан ХХК гал тогоо	122,000.0	1			131,734.6	ЦЭЭЦЭЭ МАНХАН
9.5	Өв соёлын гал тогоо болон гэрийн шат довжоо цутгах зуурмаг нийлүүлэх гэрээ, хайрга шороо татах	150,080.0			1	169,040.0	"Бараат төгс конкрет" ХХК-3, Төв Алтан шанага ххк
9.6	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал-зам талбайн ажил, зогсоолын хашлага худалдан авах, тавих	226,231.4	1		5	315,414.6	Багц-4: Төв АЗЗА ТӨХК-4, "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК-2
9.7	Өв соёлын өргөө цогцолборын тойрог замын явган хүний хашлага тавих ажил				1	14,435.6	"Төв АЗЗА" ТӨХК
9.8	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал	112,327.2	1			112,327.2	Багц-5: Төв Чандмань ДЭХГ
9.9	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх зардал-хашаа барих	76,987.9	1			87,029.7	Багц-6: Есөн хэлхээ ХХК
9.10	Өв соёлын өргөөний тугийн суурь				1	2,310.0	"Аранзал туг трейд" ХХК
9.11	Өв соёлын өргөөний ёслолын төв хаалга, тохижилтын ажлын зураг төсөл				1	3,300.0	Инж кад ХХК
10	морин хуур худалдан авах				3	56,000.0	ЦЭРЭНБАТ, ЭРДЭНЭБААТАР, АРИУНБОЛД

11	Нийтийн тээвэр төсөл	756,000.0	3	-	1	679,137.1	
11.1	Нийтийн тээвэр - Зуунмод төсөл автобус авах	740,000.0	1			440,055.0	Жойнт актив ХХК
11.2	Нийтийн тээвэр - Зуунмод төсөл автобусны буудлын сүүдрэвч цахилгаан засвар		1			40,596.1	Төв гэрэл ХХК
11.3	Нийтийн тээвэр - Зуунмод төсөл смар карт суулгах		1			46,535.0	Улаанбаатар смар карт ХХК
11.4	А687 тоот захирамжаар нийтийн тээврийн автобусны шатахуун, Цалин					87,951.1	
11.5	Нийтийн тээвэр хэрэгжүүлэх зардалд/Хот хоорондын зорчиг тээвэр/					36,000.0	
11.6	Нийтийн тээвэр Дулаан зогсоолын түрээсийн төлбөр					12,000.0	
11.7	Төв аймгийн Зуунмод сумын автобусны буудлын сүүдрэвч угсрах ажил /2ш/	16,000.0			1	16,000.0	ОБМА ХХК
12	Нэгдсэн эмнэлгийн уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх явган зам талбай байгуулах зардал	50,200.0			4	56,700.0	Ногоон заан төгөл ХХК-4
13	Одонт хөтлийн шинэчлэлийн ажил	-	-	-	8	131,617.3	
13.1	Одон хөтлийн Асфальталсан талбайн хашлага хийх, эко хавтан				4	79,659.4	Асхан ХХК-2, Хайрхант констракшн
13.2	суулгах, ногоон байгууламжийн хашааг сэргээж будах						ХХК, Сэрүүн хараат ХХК
13.3	Одонт хөтлийн гэрэлтүүлгийн засвар шинэчлэл				2	28,837.9	Мөнхтөв Тусгал, Төв гэрэл ХХК
13.4	Одонт хөтлийн цэцэрлэгт хүрээлэнгийн самбарын рамын засвар				2	23,120.0	Алтанбаганы Гантоого, Лорд дизайн ХХК

14	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар шинэчлэлийн ажил	1,019,460.9	5	-	22	1,295,268.2	
14.1	САХ -гийн төв асрын засварын ажил				3	45,136.2	Төв цогт өлзийт ХХК, ОБМА, Төв аймгийн Биеийн тамир, спортын газар /Болдын Ууганбаяр/
14.2	САХ доторх 6 жил ашигласан хүүхдийн тоглоомыг буулган авах, тоглоом худалдан авах,				3	14,554.6	ГБХЗХГ, Ургамлын далай ХХК, Батбаярын Бямбасайхан
14.3	САХ-гийн өнгө будаг сэргээх , гадна заслын ажил				3	29,687.3	МӨНХСҮХ БААСАНХҮҮ, "Дөрвөнлхагв а" ХХК, ТУСГАЛ ТӨВ ХХК
14.4	САХ-гийн Морьтой хаалганы орчмын гэрэлтүүлэг				2	39,499.7	"Төв гэрэл" ХХК-2
14.5	САХ-гийн сандал суурилуулах зардал				3	58,575.1	Асхан ХХК-2, "ОБМА" ХХК
14.6	САХ-гийн стадионы барилгын баруун урд, зүүн урд талд хөрсний ус залах суваг шуудуу татах				2	24,989.5	Даваадоржийн Данаа, Төв АЗЗА ТӨХК
14.7	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн явган зам талбайн шинэчлэлт	350,000.0	1			349,585.7	Төв АЗЗА ТӨХК
14.8	САХ-нийн баруун урд хэсэгт хөрс хуулж, хайрга дэвсэн авто зогсоол байгуулах /9000м2/	29,906.4			2	29,906.4	Гоц тех инженеринг ХХК-2
14.9	Соёл амралтын хүрээлэнгийн хашааг шинэчлэн засварлах				1	19,425.3	БТСГ
14.10	Соёл амралтын хүрээлэнд таримал зүлгийн талбайн хөрс бэлтгэл хар шороо зөөвөрлөх				3	51,095.2	Төв АЗЗА ТӨХК, Санжаагийн Ууганбаяр, Цогбатын БатЭнх

14.11	Соёл, амралтын хүрээлэнгийн гадна, дотор талын тойрог замын засвар, шинэчлэл	199,554.5	2			199,554.5	Төв АЗЗА ТӨХК-2,
14.12	Төв цэнгэлдэх хүрээлэнд сүүдрэвч хийх	240,000.0	1			235,034.3	Обма ХХК
14.13	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилдааны талбайд таримал хуйлмал зүлэг суурилуулах	200,000.0	1			198,224.4	Свебау хаус ХХК
15	Усан оргилуурын гэрэлтүүлгийн засвар	34,200.0			2	34,285.0	Зуунмод хот тохижуулах газарт-2
16	Цагдаа, олон нийтийн төв, нийтийн бие засах газрын засвар	58,964.9			3	59,021.0	Баяндөрвөлж ХХК, КлаймаксИнтернэшнл ХХК, Тантра энерги ХХК
БҮГД		3,671,360.0	16	2	98	5,118,680.7	

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн байдал

/мян.төг/

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх			
		тоо	Дүн	ИТХ		Дотоод аудит	
				тийм	үгүй	тийм	үгүй
1	2	3	4	5	6	7	7
1	Аргалант	1	64,300.00		1	1	
2	Алтанбулаг	10	421,835.22		1	1	
3	Архуст	10	141,958.55		1	1	
4	Батсүмбэр	21	673,015.44	1	-	1	
5	Баян	6	542,614.41	1	-	1	
6	Баяндэлгэр	8	429,845.20		1	1	
7	Баянжаргалан	23	590,843.80		1	1	
8	Баян-Өнжүүл	19	387,997.49		1	1	
9	Баянхангай	11	152,669.81		1	1	
10	Баянцагаан	20	771,467.20		1	1	
11	Баянцогт	12	272,400.54		1	1	
12	Баянчандмань	10	501,060.00	1	-	1	
13	Борнуур	15	514,847.54		1	1	
14	Бүрэн	13	347,664.09		1	1	
15	Дэлгэрхаан	28	421,258.31		1	1	
16	Жаргалант	17	707,956.29		1	1	
17	Заамар	10	1,053,693.10	1	-	1	
18	Зуунмод	14	651,845.17	1		1	
19	Лүн	11	321,454.93		1	1	
20	Мөнгөнморьт	16	696,827.67		1	1	
21	Өндөрширээт	14	387,148.90		1	1	
22	Сүмбэр	15	251,764.50		1	1	
23	Сэргэлэн	12	341,424.38		1	1	
24	Угтаал	17	283,239.26		1	1	
25	Цээл	6	315,867.80		1	1	
26	Эрдэнэ	17	583,992.87		1	1	
27	Эрдэнэсант	20	1,140,801.80		1	1	
	Сумын дүн	376	12,969,794.27	4	23	27	-
	Төв аймгийн ОНХС	86	12,882,286.00		1	1	
	Нийт дүн	462	25,852,080.27	4	24	28	-

**Төв аймгийн 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх
ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал**

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналт			
				Хэрэгжүүлсэн ТАХ		Хэрэгжүүлээгүй ТАХ	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8
1	Аргалант	1	64,300.00	1	64,300.00		
2	Алтанбулаг	10	421,835.22	10	421,835.22		
3	Архуст	10	141,958.55			10	141,958.50
4	Батсүмбэр	21	673,015.44	21	673,015.44		
5	Баян	6	542,614.41	1	349,380.60	5	193,233.80
6	Баяндэлгэр	8	429,845.20	1	88,400.00	7	341,445.20
7	Баянжаргалан	23	590,843.80	23	590,843.80		
8	Баян-Өнжүүл	19	387,997.49	19	387,997.49		
9	Баянхангай	11	152,669.81	11	152,669.81		
10	Баянцагаан	20	771,467.20	20	771,467.20		
11	Баянцогт	12	272,400.54	12	272,400.54		
12	Баянчандмань	10	501,060.00	10	501,060.10		
13	Борнуур	15	514,847.54	15	514,847.54		
14	Бүрэн	13	347,664.09	13	347,664.09		
15	Дэлгэрхаан	28	421,258.31	1	170,898.50	27	250,359.80
16	Жаргалант	17	707,956.29	17	707,956.29		
17	Заамар	10	1,053,693.10	8	799,916.40	2	253,776.70
18	Зуунмод	14	651,845.17	14	651,845.17		
19	Лүн	11	321,454.93	11	321,454.93		
20	Мөнгөнморьт	16	696,827.67	16	696,827.67		
21	Өндөрширээт	14	387,148.90	14	387,148.90		
22	Сүмбэр	15	251,764.50	15	251,764.50		
23	Сэргэлэн	12	341,424.38	12	341,424.38		
24	Угтаал	17	283,239.26	17	283,239.26		
25	Цээл	6	315,867.80	6	315,867.80		
26	Эрдэнэ	17	583,992.87	17	583,992.87		
27	Эрдэнэсант	20	1,140,801.80	8	676,586.30	12	464,215.50
	Сумын дүн	376	12,969,794.27	313	11,324,805	63	1,644,989.50
	Төв аймгийн ОНХС	86	12,882,286.00	85	10,406,291.26	1	2,475,994.74
	Нийт дүн	462	25,852,080.27	398	21,731,096	64	4,120,984.24

**Төв аймгийн 2023 оны ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд
мэдээлэл оруулсан байдал**

/мян. төг/

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХний	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Аргалант	3	205,110.52	2	173,969.80			1	31,140.70
2	Алтанбулаг	19	721,857.70	19	721,857.70				
3	Архуст	11	168,507.90	5	71,300.00	5	73,207.90	1	24,000.00
4	Батсүмбэр	26	981,587.80	8	321,600.00	7	516,000.00	11	143,987.80
5	Баян	7	627,622.20	1	358,351.50			6	269,270.70
6	Баяндэлгэр	9	551,848.40	3	170,000.00	1	88,400.00	5	293,448.40
7	Баянжаргалан	23	1,342,914.63	11	352,874.80			12	990,039.83
8	Баян-Өнжүүл	19	486,586.30					19	486,586.30
9	Баянхангай	20	232,368.60	20	232,368.60				
10	Баянцагаан	37	1,007,807.60	10	740,045.50			27	267,762.10
11	Баянцогт	13	322,201.30	13	322,201.30				
12	Баянчандмань	11	562,648.20	5	338,179.50	2	140,000.00	4	84,468.70
13	Борнуур	15	550,124.60	11	445,408.00			4	104,716.60
14	Бүрэн	14	563,899.50	6	351,099.50	5	90,000.00	3	122,800.00
15	Дэлгэрхаан	29	917,857.60					29	917,857.60
16	Жаргалант	26	919,851.80	24	899,851.80			2	20,000.00
17	Заамар	16	1,477,286.60	16	1,477,286.60				
18	Зуунмод	18	851,917.10	18	851,917.10				
19	Лүн	21	334,249.00	9	231,248.30			5	103,000.70
20	Мөнгөнморьт	14	405,318.00	13	284,182.40			3	121,135.60
21	Өндөрширээт	21	1,036,037.60	11	882,337.60	3	153,700.00		
22	Сүмбэр	21	334,249.00			8	167,264.50	13	166,984.50
23	Сэргэлэн	14	405,318.00	11	396,868.10			3	8,449.90

24	Угтаал	21	1,036,037.60	21	1,036,037.60				
25	Цээл	9	571,621.10	5	400,621.10			4	171,000.00
26	Эрдэнэ	22	889,096.80	20	832,939.60			2	56,157.20
27	Эрдэнэсант	21	1,649,380.10	14	804,143.60	2	124,236.50	5	721,000.00
	Сумын дүн	480	19,153,305.55	276	12,696,690.00	33	1,352,808.90	159	5,103,806.63
	Төв аймгийн ОНХС	86	13,281,230.20					86	13,281,230.20
	Нийт дүн	566	32,434,535.75	276	12,696,690.00	33	1,352,808.90	245	18,385,036.83

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

/мян.төг/

№	Сумын нэр	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл						Зөрчил
		Мэдээлбэл зохих		Үүнээс:				
				Мэдээлсэн		Мэдээлээгүй		
		Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	
1	Аргалант	3	205,110.50	3	205,110.50	-	-	
2	Алтанбулаг	19	721,857.70	13	527,790.00	6	194,067.70	
3	Архуст	11	168,507.90	9	112,507.60	2	56,000.30	
4	Батсүмбэр	26	981,587.80	25	848,534.30	1	133,053.50	
5	Баян	7	627,622.20	1	358,351.80	6	269,270.40	
6	Баяндэлгэр	9	551,848.40			9	551,848.40	Гүйцэтгэлийг огт мэдээлээгүй.
7	Баянжаргалан	23	1,342,914.60	19	1,263,930.60	4	78,984.00	
8	Баян-Өнжүүл	19	486,586.30	19	486,586.30	-		11, 12-р сарын мэдээллийг оруулаагүй.
9	Баянхангай	20	232,368.60	14	232,368.60	6		2,4,6,7,9,12 сарын мэдээллийг хоцроож мэдээлсэн.
10	Баянцагаан	37	1,007,807.60	10	783,210.60	27	224,597.00	1,3,7,8,9,10,11 сарын мэдээллийг хоцроож мэдээлсэн.
11	Баянцогт	13	322,201.30	13	312,201.30	-	10,000.00	1-9 сар болон 11 сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
12	Баянчандмань	11	562,648.20	11	562,648.20	-		6,8,9 сарын мэдээллийг хоцроож мэдээлсэн.
13	Борнуур	15	550,124.60	15	550,124.60	-		
14	Бүрэн	14	563,899.50	8	440,273.50	6	123,626.00	
15	Дэлгэрхаан	29	917,857.60	4	264,042.20	25	653,815.40	
16	Жаргалант	26	919,851.80	26	919,851.80	-		
17	Заамар	16	1,477,286.60	9	1,477,286.60	7		
18	Зуунмод	18	851,917.10	11	625,137.00	7	226,780.10	Өгсөн санхүүжилт, гүйцэтгэгчийн мэдээллийг оруулаагүй байна.
19	Лүн	14	445,692.90	10	332,219.50	4	113,473.40	
20	Мөнгөнморьт	16	1,082,438.80	16	1,076,610.80	-	5,828.00	1-3 сарын мэдээллийг хоцроосон.
21	Өндөрширээт	14	666,510.00	14	666,510.00	-		1-7 болон 9,11 сарын мэдээллийг хоцроосон.
22	Сүмбэр	21	334,249.00	9	191,830.00	12	142,419.00	
23	Сэргэлэн	14	405,318.00	14	405,318.00	-		
24	Угтаалцайдам	21	1,036,037.60	14	865,000.00	7	171,037.60	
25	Цээл	9	571,621.10	9	571,621.10	-		
26	Эрдэнэ	22	889,096.80	22	889,096.80	-		
27	Эрдэнэсант	21	1,649,380.10	21	844,380.10	-	805,000.00	
28	Аймгийн ОНХС	65	12,882,286.00	65	12,882,286.00	-	-	2,5,7,8,9,10,11,12 сарын мэдээллийг хоцроож мэдээлсэн.
	ДҮН	533	32,454,626.70	404	28,694,827.90	129	3,759,800.80	